



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 сны 02 сарын 02 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 201 дугаар тушаал, “Эм Даблью Ти Эс УЦК” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2015 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 01/03 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Эм Даблью Ти Эс УЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 2 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
- Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Эм Даблью Ти Эс УЦК” ХХК /Г.Энхдэлгэр/-д анхааруулсугай.
- Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР